

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.Нямбаатар

Х.НЯМБААТАР

2025 оны сарын өдөр

“НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР”-ЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.Батсүх

Д.БАТСҮХ

Улаанбаатар хот
2025 он

АГУУЛГА

НЭГ.	НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	3
ХОЁР.	МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ.....	3
ГУРАВ.	АЛСЫН ХАРАА.....	13
ДӨРӨВ.	ЭРХЭМ ЗОРИЛГО.....	13
ТАВ.	ҮНЭТ ЗҮЙЛС	13
ЗУРГАА.	ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ.....	13
ДОЛОО.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО.....	17
НАЙМ.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОД ТҮВШИН.....	18
ЕС.	СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА.....	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Мандатын шинжилгээ
- Хүснэгт 2. Чиг үүрэг, эрх хэмжээ
- Хүснэгт 3. Холбогдогч талуудын оролцоо
- Хүснэгт 4. Чиг үүргийн хэрэгжилт

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагаанд холбогдогч талууд
- Зураг 2. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын бүтцийн схем
- Зураг 3. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын стратегийн зорилго ба бүтцийн уялдаа

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль батлагдсанаар улсын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичгийг уялдуулах, үр дүнд суурилсан төлөвлөлтийн тогтолцоог төлөвшүүлэх эрх зүйн үндэс бүрдсэн. Энэ хуулийн дагуу нийслэл хотын түвшинд дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг нь "Нийслэлийг 2025-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг нь "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" байх ба эдгээр нь уялдаа холбоотой, шаталсан төлөвлөлтийн зарчмаар хэрэгжинэ.

Үүний үр дүнд Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна", "Алсын хараа -2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Шинэ сэргэлтийн бодлогод тулгуурлан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам" болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 100 дугаар тушаалаар шинэчлэгдсэн "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-д нийцүүлэн "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулав.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Мандатын буюу чиг үүргийн шинжилгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ын хүрээнд нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/08 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-тэй уялдуулан хийж гүйцэтгэв.

Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-д зааснаар "чиг үүрэг" гэж төрийн байгууллага хуульд заасан эрх мэдлийн хүрээнд тодорхой зорилт, үр дүнд хүрэхээр тогтвортой хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэлнэ.

Мандатын шинжилгээгээр тус байгууллагын эрхлэх асуудал нь нийт 18 хуулийг хамарч байна. Үүнээс байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд шууд хамаарах 1 хуулийн хүрээнд чиг үүргийг нарийвчлан тодорхойллоо.

Хүснэгт-1. Мандатын шинжилгээ

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		18
Үүнээс :	Тухайн салбарын хуулийн тоо	1
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	17
Ерөнхий чиг үүрэг-1. Аялал жуулчлалын хөгжлийн бодлогыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх		

Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
1. Нийслэлийн Аялал жуулчлалын бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлэх	1.1. Аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах	
	1.2. Аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	
	1.3. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах	Төрийн захиргааны төв байгууллагууд
	1.4. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах	Нийслэлийн Засаг даргын Тамын газар Олон Улсын байгууллагууд
	1.5. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах	Мэргэжлийн холбоод Сургалт судалгааны байгууллагууд
	1.6. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Төрийн бус байгууллагууд
	1.7. Хариуцсан чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, үндэсний болон норм стандартад санал өгөх, төсөл боловсруулах	Иргэд, Аж ахуй нэгж байгууллага
	1.8. Нийслэлийн аялал жуулчлалын нөөцөд	

	түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах	
2. Улаанбаатар хотыг сурталчлах маркетингийн бодлого хэрэгжүүлэх	2.1. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах маркетингийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих	
	2.2. Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг хамруулах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Төрийн захиргааны төв байгууллагууд
	2.3. Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг хамруулах	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Олон Улсын байгууллагууд
	2.4. Гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, мэдээллийн товхимлуудыг тогтмол шинэчлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	Мэргэжлийн холбоод Сургалт судалгааны байгууллагууд
	2.5. Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын мэдээллийн санг хөтлөх	Төрийн бус байгууллагууд
	2.6. Жуулчны мэдээллийн төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх	Иргэд, Аж ахуй нэгж байгууллага
	2.7. Жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх	
	2.8. Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран	

	ажиллах	
3. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах	3.1.Хууль тогтоомжоор олгосон эрх хэмжээний хүрээнд тушаал гаргах, газрын хөдөлмөрийн дотоод журам, холбогдох дүрэм, журмыг баталж мөрдүүлэх;	
	3.2.Батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд хууль, журмын дагуу албан хаагчдыг томилох, чөлөөлөх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулах;	
	3.3.Албан хаагчидтай гүйцэтгэлийн төлөвлөгөө, төрийн үйлчилгээний албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Нийслэлийн Засаг даргын Тамын газар
	3.4.Сахилга, дэг журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, эд хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, хамгаалалтад хяналт тавьж, зөрчил, дутагдлыг арилгах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах;	Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөл Олон Улсын байгууллагууд
	3.5.Албан хаагчдын нийгмийн асуудлыг хууль тогтоомж, хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулах;	Мэргэжлийн холбоод Сургалт судалгааны байгууллагууд
	3.6.Газрын үйл ажиллагааг хэвийн явуулах, ажлын байрны чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, уялдаа холбоог сайжруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авах;	Төрийн бус байгууллагууд
	3.7.Хариуцсан чиг үүрэгт хамаарах асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм стандартад санал өгөх, дүрэм, журам, норм, үндэсний болон хотын стандартын төсөл боловсруулах, хүчин	Иргэд, Аж ахуй нэгж байгууллага

	төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, норм стандартыг мөрдүүлэх;	
	3.8.Хариуцсан чиг үүрэгт хамаарах асуудлаар удирдах албан тушаалтанд хандаж санал гаргах, шийдвэрлүүлэх;	
	3.9.Хариуцсан чиг үүрэгт хамаарах асуудлаар удирдах албан тушаалтан, холбогдох байгууллага, албан хаагчдыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангах;	
	3.10.Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	
	3.11.Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтарч ажиллах;	
	3.12.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг	

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын чиг үүргийг холбогдох эрх зүйн баримт бичигт тулгуурлан тодорхойлсон бөгөөд тухайн чиг үүргийг захиргааны эрх хэмжээний ангиллаар авч үзсэн. Энэ хүрээнд Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан чиг үүрэг дахин хуваарилах аргачлалыг суурь болгон үзвэл дараах байдлаар тодорхойлогдоно:

1. **Бодлого боловсруулах:** Аялал жуулчлалын салбарын болон нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгах санал боловсруулах
2. **Зохицуулалт хийх:** Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа зочлох үйлчилгээний байгууллагуудыг бүртгэнэ.
3. **Зохион байгуулах:** Аялал жуулчлалын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулна.
4. **Санхүүжилт:** Нийслэлийн төсөв, хөрөнгө оруулалт
5. **Хүний нөөцийн бодлого:** Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
6. **Хяналт шинжилгээ, үнэлгээ:** Байгууллагын дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шалгалт болон дотоод аудитыг хууль журамд заасан хугацаанд хийнэ.
7. **Үйлчилгээ үзүүлэх:** Улаанбаатар хотын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа зочлох үйлчилгээний байгууллагуудыг бүртгэх үйлчилгээ үзүүлнэ.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын чиг үүргийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт-2. Чиг үүрэг, эрх хэмжээ

	Чиг үүрэг	Захиргааны эрх хэмжээ						
		Бодлого боловсруулах:	Зохицуулалт хийх:	Зохион байгуулах:	Санхүүжилт:	Хүний нөөцийн бодлого:	Үйлчилгээ үзүүлэх:	Хяналт шинжилгээ үнэлгээ:
1	Аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах;		+	+	+	+	+	+
2	Аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;	+	+	+		+	+	
3	Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах маркетингийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;	+	+	+	+		+	
4	Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах;	+	+	+	+		+	
5	Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;			+	+		+	
6	Аялал жуулчлалын	+	+	+	+	+	+	

	салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;							
7	Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;	+	+	+	+	+	+	
8	Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарт соёлын нөлөөллийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;	+	+	+	+			+
9	Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг хамруулах;			+	+		+	
10	Нийслэлийн аялал жуулчлалын нөөцөд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах;		+	+	+		+	
11	Гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, мэдээллийн товхимлуудыг тогтмол шинэчлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;			+	+		+	
12	Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын мэдээллийн санг хөтлөх;			+	+		+	
13	Жуулчны мэдээллийн төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх;			+	+	+	+	
14	Жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх;			+			+	
15	Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр		+	+	+		+	

холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.							
---	--	--	--	--	--	--	--

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргаас бусад байгууллагуудтай харилцах эрх хэмжээг үндэслэн тодорхойлов.

Зураг 1. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын үйл ажиллагаанд холбогдогч талууд



Эдгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлсон болно. Нийслэлийн Аялал жуулчлалын газар нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эдгээр холбогч талуудтай харилцах бөгөөд холбогч талууд өөрт хамаарах эрх хэмжээний хүрээнд тодорхой үүрэг оролцоотойгоор хамтран ажиллана.

Хүснэгт 3. Холбогдогч талуудын оролцоо

Холбогдогч талууд	Оролцоо					
	Мэдээлэх	Зөвлөх, эргэх холбоогоор хангах	Санал өгөх	Хамтран ажиллах	Шийдвэр гаргах	Хяналт тавих
Нийслэлийн Засаг дарга	✓	✓	✓	✓	✓	✓
Нийслэлийн Засаг даргын тамгын газар	✓	✓	✓	✓	✓	✓
НИТХ	✓	✓	✓	✓		
УИХ	✓					
Засгийн газар	✓					
ЗГХЭГ	✓					
Төрийн захиргааны төв	✓	✓	✓	✓		

байгууллагууд						
Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба	✓	✓	✓	✓		
Элчин сайдын яамууд	✓			✓		
Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагууд	✓	✓	✓	✓		
Засгийн газрын агентлагууд	✓	✓	✓	✓		
Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд	✓	✓	✓	✓		
Олон улсын байгууллагууд	✓	✓	✓	✓		
Дүүргийн Засаг дарга нар	✓	✓	✓	✓		
Олон нийтийн болон төрийн бус байгууллагууд	✓	✓	✓	✓		
Хэвлэл мэдээллийн байгууллагууд	✓	✓		✓		
Сургалт, судалгааны байгууллага	✓	✓	✓	✓	✓	✓
Иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд	✓	✓	✓	✓	✓	✓

Чиг үүргийн хэрэгжилтийн талаарх үнэлгээг гаргахдаа Нийслэлийн Аялал жуулчлалын газрын ажилтнууд болон холбогдох талуудын дунд явуулсан санал асуулгын үр дүнд тулгуурласан.

Хүснэгт 4. Чиг үүргийн хэрэгжилт

№	Чиг үүрэг	Чиг үүргийн хэрэгжилтийн хувь	Холбогдогч талуудын үнэлгээ	Дундаж хувь
1.	Аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах;	85.9	80	82.95
2.	Аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;	81.4	85	83.2
3	Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах маркетингийн төлөвлөгөө	83.5	87	85.25

	боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;			
4.	Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах;	80	75	77.5
5.	Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;	90.5	85	87.75
6.	Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;	79.6	90	84.8
7.	Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;	75	82	78.5
8.	Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарт соёлын нөлөөллийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;	96.8	90	93.4
9.	Гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг хамруулах;	90.7	85	87.85
10.	Нийслэлийн аялал жуулчлалын нөөцөд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах;	87	83	85
11.	Гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, мэдээллийн товхимлуудыг тогтмол шинэчлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;	96.5	91	93.75
12.	Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын мэдээллийн санг хөтлөх;	81	75	78
13.	Жуулчны мэдээллийн төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх;	94	96	95
14.	Жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх;	85		
15.	Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.	90	85	87.5

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Аялал жуулчлалын олон талт бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий Монгол Улсын аялал жуулчлалын гол зангилаа хот байна.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Нийслэл Улаанбаатар хотыг үндэсний онцлог бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ өндөр хөгжсөн, олон улсад өрсөлдөх чадвартай хот болгон хөгжүүлэхэд оршино.

ТАВ. ҮНЭТ ЗҮЙЛ

Хууль ёсыг дагах. Монгол Улсын хууль тогтоомжийг чандлан сахиж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

Нотолгоонд суурилах. Нийслэлийн нийгэм эдийн засгийн судалгаа, статистикийн үнэн бодит тооцоо судалгаанд үндэслэх.

Инновацилаг байх. Шинэ санаа, оновчтой шийдлийг эрэлхийлэх.

Мэдлэгийг эрхэмлэх. Мэдлэгээ байнга хөгжүүлж, орчин үетэйгээ хөл нийлүүлэн, өндөр үр өгөөж бүхий ухаалаг тогтолцоо, шийдэл, технологийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх.

Шударга, хариуцлагатай. Шударга байх зарчмыг үйл ажиллагаандаа баримталж, хариуцсан ажилдаа хариуцлагатай хандах.

Хүн төвтэй. Нийслэлийн хөгжлийн гол тулгуур нь хүн төвтэй шийдэл байх ёстойг үндсэн зарчмаа болгон ажиллах.

Чадварлаг. Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд ур чадвар, орчин үеийн шийдэл, мэдээлэл технологийг эзэмшиж, үр бүтээлтэй ашиглах.

ЗУРГАА. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын өмнө тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд SWOT болон PESTLE шинжилгээг дотоод болон гадаад хүчин зүйлийн хүрээнд хийлээ.

Стратегийг боловсруулахын тулд хуулийн хүрээнд тодорхойлогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхын өнөөгийн давуу, сул тал, орчны нөлөөллийн боломж эрсдэлийг илэрхийлэх гол хүчин зүйлсийг тус тус сонгож авсан болно.

Стратегийн зорилтыг тодорхойлохдоо тус шинжилгээний үр дүнд тулгуурлан давуу талдаа түшиглэн, сул талаа бууруулахад чиглэсэн арга замыг сонгож, гадаад орчны боломжийг ашиглаж, эрсдэлийг бууруулах зарчмыг баримталсан.

Орчны шинжилгээ /SWOT/

ДОТООД ОРЧИН	
Давуу тал 1. Албан хаагчид урт хугацаанд тогтвор суурьшилттай ажилладаг. 2. Аялал жуулчлалын мэргэжлийн албан хаагчид дийлэнх хувийг эзэлдэг. 3. Олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөл бололцоо сайн 4. Салбартаа нэр хүндтэй.	Сул тал 1. Байгууллагын төсөв хангалтгүй. 2. Ажлын байрны орчин нөхцөл хангалтгүй. 3. Албан хэрэгцээний техник тоног төхөөрөмжийн хүчин чадал муу 4. Байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэхэд батлагдсан орон тоо хүрэлцээгүй. 5. Ажлын байр хол, авто замын түгжрэл ихтэй

5. Байгууллага дотооддоо уян хатан цагийн зохицуулалттай.	6. Албан хаагчдын сургалт, нийгмийн баталгааг хангах чиглэлээр төсөв тавигддаггүй.
ГАДААД ОРЧИН	
Боломж 1. Олон улсын болон дотоодын байгууллагын туршлагаас суралцах, тэдгээрийг нэвтрүүлэх үүднээс гадаад хамтын ажиллагааг тогтмол сайжруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх 2. Орон нутгийн болон салбарын дээд шатны байгууллага, бүх төрлийн хуулийн этгээдтэй үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах	Эрсдэл 1. Улс төрийн тогтворгүй байдал байгууллагын удирдлага, хүний нөөц болон салбарын тогтвортой байдалд нөлөөлдөг. 2. Дээд байгууллагуудаас хугацаа шахуу цаг тулсан ажлуудын үүрэг даалгавар байнга өгөгддөг нь ажлын ачааллыг нэмэгдүүлдэг. 3. Батлагдсан ажлын санхүүжилтийг зогсоох, арга хэмжээг цуцлах шийдвэр гаргадаг. 4. Арга хэмжээнүүдийн нийтэд зарласан товыг өөрчилдөг.

SWOT шинжилгээ нь байгууллагын дотоод давуу болон сул тал, гадаад орчны боломж ба аюул заналыг илрүүлэн тодорхойлох стратегийн чухал хэрэгсэл юм. Энэхүү шинжилгээний зорилго нь байгууллагын өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ өгч, цаашдын хөгжлийн стратегийг оновчтой төлөвлөхөд оршино. SWOT шинжилгээ хийснээр байгууллага дотоод нөөц боломжоо бүрэн ашиглах, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх, мөн гадна орчны эерэг боломжийг ашиглан сөрөг нөлөөллөөс сэргийлэх суурь мэдээллийг олж авдаг. Иймд SWOT шинжилгээ нь стратеги төлөвлөгөө боловсруулах үйл явцын голлох хүчин зүйл болдог бөгөөд байгууллагын удирдлагад шийдвэр гаргахдаа баримтлах бодит үндэслэл, нотолгоог бүрдүүлдэг.

Гадаад орчны хувьд SWOT шинжилгээг баяжуулан PESTLE шинжилгээ давхар хийх замаар тодорхойллоо. Улаанбаатар хотын аялал жуулчлалын салбарт нөлөөлж буй гадаад хүчин зүйлсийг улс төр, эдийн засаг, нийгэм соёл, техник, технологи, хууль эрх зүй, байгаль орчны зүгээс үзүүлэх нөлөөллийг тодорхойлон, ямар эерэг боломж, ямар сөрөг нөлөөлөл, эрсдэл байгааг гаргав.

Гадаад орчны шинжилгээ /Pestle/

Үзүүлэлт	Хамаарах гол эерэг, сөрөг хүчин зүйлс	Нэмэлт тайлбар
Улс төр	✓ Засгийн газраас салбарын үйл ажиллагааг дэмжих зорилгоор баталсан тогтоол, шийдвэрүүд эерэг үр дагавартай. ✓ Салбарын удирдлагууд ойр ойрхон өөрчлөгддөгөөс бодлогын залгамж, чанар алдагддаг. ✓ Дээд байгууллагаас хамаарсан гэнэтийн шийдвэр нь салбарын төлөвлөлт, үйл ажиллагаанд сөрөг нөлөөтэй. ✓ Олон улсын Геополитикийн тогтворгүй байдал жуулчдын	Монгол Улсын засгийн газраас 2023-2028 оныг монголд зочлох жил болгон зарласан нь гадаад сурталчилгаа сайжирч зорин ирэх жуулчдын тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд хотын удирдлага солигдох бодлогын өөрчлөлтөөс шалтгаалан бүтэц, чиг үүрэг өөрчлөгдөх санхүүжилт тасрах зэрэг улс төрийн эрсдэлтэй.

	урсгалд сөрөг нөлөөтэй.	Удирдлагууд тогтвортой байснаар дунд богино хугацааны бодлогын төлөвлөлтүүд тасралтгүй явагдаж салбарын тогтвортой хөгжлийн бодлого хэрэгжинэ.
Эдийн засаг	✓ Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн өсөлтөөс шалтгаалан зорин ирэх жуулчдын тоо цөөрөх эдийн засагт оруулах валютын нөөц багасах ✓ Олон улсын нислэгийн тоог нэмж байгаа ✓ Олон улсын жуулчин нэвтрэх боомтын тоо өссөн ✓ Монголд аялахад визийн хөнгөлөлт нэмэгдсээр байна ✓ Дотоодын аялал жуулчлал нэмэгдсэн, иргэдийн аялал жуулчлалын талаарх мэдлэг дээшилсэн ✓ Бүс нутгийн болон хөрш орнуудын эдийн засаг өсөлттэй, тогтвортой байгаа. ✓ Салбарын хөрөнгө оруулалт бага ✓ Бүтээгдэхүүн үйлчилгээг валютаар шууд худалдан авах боломжгүй.	Зорин ирэх жуулчдын тоо нэмэгдсэнээр Улсын эдийн засагт орох валютын нөөц нэмэгдэнэ. 1 жуулчин ирэхэд 5 ажлын байр нэмэгддэг бөгөөд 9 салбар шууд хамааралтай бусад бүх салбартай шууд болон шууд бусаар холбогдож эдийн засгийн үр өгөөж хүртээдэг; Гадаад болон дотоод орчны өөрчлөлтөөс бий болж байгаа эрсдэлийг цаг алдалгүй тооцон удирдаж тогтмол шинэчлэлт, өөрчлөлт хийхэд нийслэлийн төсвөөс хангалтгүй олгодог нь үйл ажиллагаа, арга хэмжээ цар хүрээгээ тэлэх чадамжгүй болдог
Нийгэм	✓ Гадаад улс оронд аялах бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдсэн. ✓ Цахим орчноос аялал жуулчлалын мэдээллийг богино хугацаанд авдаг болсон ✓ Залуучууд аялах сонирхол идэвхтэй болсон. ✓ Олон нийтийн аяллын боловсрол, соёл дутмаг	Залуучууд шинэ газар үзэх, адал явдалт болон өөрийгөө хөгжүүлэх аялалд илүү идэвхтэй оролцдог болсон. Энэ нь дотоодын аялал жуулчлалын шинэ сегмент бий болгох, өвөрмөц бүтээгдэхүүн хөгжүүлэх боломжтой. Зарим жуулчид болон дотоодын аялагчид байгальд хог хаях, дурсгалт газрыг эвдэх, дэг журам сахиxгүй байх зэрэг сөрөг дадалтай байдаг нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж, аяллын туршлагыг муутгадаг. Үүнийг бууруулахын тулд олон нийтэд чиглэсэн аяллын боловсрол, хариуцлагатай аяллын сургалт, сурталчилгааг тогтмол хийх

		хэрэгцээ байна.
Технологи	✓ Онлайн захиалга, цахим маркетинг, аппликейшнүүд хөгжиж байна. ✓ Хотын ухаалаг үйлчилгээ бүрэн хөгжөөгүй (Wi-Fi, e-map, QR мэдээлэл). ✓ Виртуал аялал, хиймэл оюун ухааны хэрэглээ хөгжөөгүй (AI guide, chatbot). ✓ Нийтийн тээврийн дижитал системүүд дотоодын үйлчлүүлэгчдэд хөгжүүлэлт мэдээлэл сайн боловч гадаад жуулчдад зориулсан хэлний сонголт, төлбөрийн систем дутмаг (UB smart bus, цахим төлбөр)	Гадаад орчинд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд дижитал бүтээгдэхүүнүүдийн эрэлт хэрэгцээ нэн шаардлагатай байгаа бөгөөд сайжруулалт хөгжүүлэлт хийгдэж байгаа ч төдийлөн гадаад улс орны жуулчид ашиглах боломжгүй байна. Байгууллагын технологийн нөөц компьютер тоног төхөөрөмжийн хангамж сайн боловч программ хангамж, аюулгүй байдал хангалтгүй. Мэдээлэл солилцож буй байгууллагуудын систем доголдож, шаардлагатай мэдээллийг цаг хугацаандаа авч чадахгүй байх; Цахим систем хэрэглэгчид интернэт, харилцаа холбооны асуудал үүсэх; Байгууллагын www.tourism.ub.gov.mn веб хуудас, жуулчдын нэгдсэн мэдээ, мэдээллээр хангах www.visitulaanbaatar.net -ын нэмэлт хөгжүүлэлтэд зайлшгүй шаардагдах төсөв байхгүй. (жил бүр байгууллагын төсөвт суулгадаг байх)
Хууль эрх зүй	✓ Зарим үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд хууль эрх зүйн зохицуулалт хангалтгүй. ✓ Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд зөрчил гаргасан тохиолдолд хүлээлгэх хариуцлага сул	Хууль, журам, дагаж мөрдөх стандарт тодорхой байснаар үйлчилгээний чанар стандарт алдагдахгүй, жуулчдад тулгарах эрсдэлийг багасгах боломжтой.
Байгаль орчин	✓ Агаар орчны бохирдол, хог хаягдлын асуудал жуулчдад сөргөөр нөлөөлдөг ✓ Эрс тэс уур амьсгалаас	Хотын иргэд болон жуулчдад зориулсан ногоон байгууламж, амралт чөлөөт цагийн бүсүүд хүрэлцээ

	хамааран, улирлын хамааралтай аялал жуулчлал түлхүү явагддаг (өвөл, зун жуулчдын тоо ялгаатай) ✓ Байгальд түшиглэсэн эко аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. ✓ Хотын ногоон байгууламж, амралт чөлөөт цагийн бүсүүдийн хүртээмж сул	муутай, зарим нь чанаргүй арчилгаа, үйлчилгээтэй. Энэ нь хотын аялал жуулчлалын сонирхлыг бууруулдаг, жуулчид богино хугацаанд зөвхөн үзвэрийн газруудыг үзээд шууд явах шалтгаан болдог.
--	--	--

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Стратеги зорилго: Улаанбаатар хотын аялал жуулчлалын эдийн засгийн үр нөлөөг нэмэгдүүлнэ. Стратегийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ.

1. Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.
2. Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.
3. Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж ажиллана.
4. Зочлох үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангуулж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.
5. Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.
6. Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.
7. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, хүний нөөцийн бодлогыг сайжруулна.

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОД ТҮВШИН

Стратегийн зорилт	Хэрэгжүүлэх арга зам	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2024 он)	Зорилтот түвшин (2025-2028 он)	Санхүүгийн эх үүсвэр
1	2	3	4	5	6
Үндсэн чиг үүрэг: Нэг Дөрвөн улирлын аялал жуулчлалын арга хэмжээг хэрэгжүүлэх					
	Арга хэмжээ - 1.1 Аялал жуулчлалын мэдээлэл сурталчилгааны төвийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Батлагдсан төсвийн хүрээнд
1. Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.	Арга хэмжээ – 1.2 Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын шинж чанартай томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулна.	Оролцогч, сонирхогч жуулчдын тоо	70,000	150,000	Батлагдсан төсвийн хүрээнд
	Арга хэмжээ – 1.3 Улаанбаатар хотын тойрон аяллын "Сити тур" төслийг үргэлжлүүлэх	Нийслэлийн төсөвт орлого төвлөрүүлэх хувь	100	100	Батлагдсан төсвийн хүрээнд
	Арга хэмжээ – 1.4 Жуулчдын зорин очих газар, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх	Бүтээгдэхүүний тоо	1	3	Батлагдсан төсвийн хүрээнд
2. Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын	Арга хэмжээ - 2.1 Өвлийн улиралд жуулчдын тоог нэмэгдүүлэх чиглэлээр маркетинг сурталчилгааны ажлыг зохион	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Батлагдсан төсвийн хүрээнд

улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	байгуулна.				
3. Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.	Арга хэмжээ - 3.1 Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын шинж чанартай томоохон арга хэмжээнд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хамруулна.	Арга хэмжээнд хамруулсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тоо	488	650	Батлагдсан төсвийн хүрээнд
	Арга хэмжээ - 3.2 Хот, дүүргүүдэд жуулчны зорин очих газар, худалдаа үйлчилгээний гудамж бий болгоно.	Гудамжны тоо	-	3	Батлагдсан төсвийн хүрээнд
4. Зочлох үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангуулж, салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Арга хэмжээ – 4.1 Үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах сургалтуудыг зохион байгуулна.	Сургалтын тоо	2	8	Батлагдсан төсвийн хүрээнд
	Арга хэмжээ – 4.2 Үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах арга хэмжээг зохион байгуулах	Стандартын хяналтад хамрагдсан байгууллагууд	44	100	Батлагдсан төсвийн хүрээнд
5. Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.	Арга хэмжээ - 5.1 Улаанбаатар хотын танилцуулга сэтгүүл, цахим сэтгүүл, газрын зураг, хөтөч ном, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх контент зэргийг шинэчлэн гаргана.	Сурталчилгааны материалын тоо	25,000	40,000	Батлагдсан төсвийн хүрээнд
	Арга хэмжээ - 5.2 Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг орчин	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Батлагдсан төсвийн хүрээнд

	үеийн дэвшилтэд технологиуд ашиглан хийж гадаад улс оронд сурталчлах		100	100	
	Арга хэмжээ - 5.3 Олон улсад алдартай аялагч нартай хамтран ажиллаж, Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Батлагдсан төсвийн хүрээнд
	Арга хэмжээ - 5.4 Олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран олон нийтийн цахим сүлжээгээр Улаанбаатар хотын маркетинг сурталчилгааг хийх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Батлагдсан төсвийн хүрээнд
	Арга хэмжээ - 5.5 Оюутан цагдаа хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Батлагдсан төсвийн хүрээнд
	Арга хэмжээ - 5.6 Жуулчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр контент хийж, жуулчид ихээр зорчдог байршлуудаар сурталчлах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Батлагдсан төсвийн хүрээнд
6. Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.	Арга хэмжээ - 6.1 Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчилна.	Оролцсон олон улсын үзэсгэлэнгийн тоо	6	10	Батлагдсан төсвийн хүрээнд
	Арга хэмжээ - 6.2 Улаанбаатар хотын соёл, аялал жуулчлалын өдрүүдийг зохион байгуулах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	4	Батлагдсан төсвийн хүрээнд

	Арга хэмжээ - 6.3 Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах фам турыг хот болон хот орчимд зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Батлагдсан төсвийн хүрээнд
Үндсэн чиг үүрэг: Хоёр Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.					
7.1. Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулна.	7.1.1 Газрын алсын хараа ба зорилгыг нийслэлийн хөгжлийн бодлоготой уялдуулан сайжруулах	Шинжилгээ, судалгаанд суурилсан шинэ бодлоготой уялдуулсан байна.	-	100	-
	7.1.2 Стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээний KPI аргачлалыг нэвтрүүлэх	Биелэлт, тайлан гаргахдаа KPI аргачлалыг ашигласан байна.	-	100	-
	7.1.3 Газрын алсын хараа, үнэт зүйл, зорилгыг ажилчдад ойлгомжтой байдлаар түгээн, дотоод сургалт, хэлэлцүүлгээр дамжуулан хамтран тодорхойлох.	Алсын хараа, үнэт зүйл, зорилгыг нийт ажилтнуудад ойлгомжтой болгож, хамтран тодорхойлох, стратегийн сургалт, хэлэлцүүлэг 2 жилд нэг удаа зохион байгуулсан байна.	-	100	Батлагдсан төсвийн хүрээнд
7.2. Байгууллагын соёл ба манлайлалыг хөгжүүлнэ.	7.2.1 Байгууллагын шаардлагатай журмуудыг боловсруулах, бүх түвшинд хэрэгжилтийг хангах, сургалт явуулах.	Байгууллагын дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийн хагас жил тутамд тайлагнасан байна. Батлагдсан дүрэм журмыг албан хаагчдад танилцуулж, сургалт зохион байгуулсан байна. Сургалтад оролцсон ажилтнуудын хувь $\geq 90\%$	-	100	Батлагдсан төсвийн хүрээнд

		Байгууллагын дэргэдэх зөвлөлүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлж, урамшуулсан байна.			
	7.2.2 Манлайллын түвшинд "coaching & mentoring" хөтөлбөр нэвтрүүлэх	"Coaching & Mentoring" хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.	-	100	Батлагдсан төсвийн хүрээнд
	7.2.3 Дотоод харилцаа ба хамтын ажиллагааг дэмжих орчныг бий болгож, ил тод мэдээллийн хүртээмжийг хөгжүүлэх	Дотоод харилцаа ба ил тод байдлыг сайжруулах. Байгууллагын мэдээллийн ил тод байдлын журмыг боловсруулан хэрэгжүүлсэн байна. Ажилтнуудын дотоод мэдээллийн хүртээмжийн үнэлгээ $\geq 85\%$	-	100	-
	7.2.4 Шинэ санаачилга, бүтээлч байдлыг дэмжих орчныг бүрдүүлэх	Албан хаагчдын санал, санаачилгыг дэмжих "Бүтээлч санаа" уралдаан, шагналын тогтолцоо нэвтүүлсэн байна.	-	100	Батлагдсан төсвийн хүрээнд
	7.2.5 Гүйцэтгэлд суурилсан урамшуулал, хариуцлагын тогтолцоог нэвтрүүлэх	Албан хаагчдын гүйцэтгэлийг бодит үзүүлэлтээр үнэлж, амжилтыг урамшуулах, сахилга хариуцлагын тогтолцоог нэвтрүүлсэн байна	-	100	-
	7.2.6 Байгууллагын соёлын үнэлгээ, дотоод сэтгэл ханамжийн судалгааг жил бүр хийх	Судалгааны үр дүнд үндэслэн сайжруулалтын арга хэмжээ жил бүр авч	-	100	-


		хэрэгжүүлсэн байна.			
7.3. Оролцогч талуудын оролцоо хангана.	7.3.1 Төр, хувийн хэвшил, мэргэжлийн холбоодыг хамарсан оролцогч талуудын зөвлөл байгуулж, бодлого шийдвэрт оролцуулах.	Оролцогч талуудын зөвлөл байгуулах Хэлэлцсэн саналын 70%-ийг шийдвэр гаргалтад тусгадаг байна.	-	100	-
	7.3.2 Газрын бодлого, үйл ажиллагааны ил тод байдлыг хангах нээлттэй дата сан болон олон нийтэд нээлттэй тайлангийн системийн хэрэгжилтийг тогтмол хангах.	Дата сан тогтмол ажиллагаатай, мэдээлэл шинэчлэгдэж байгаа эсэхэд хяналт шинжилгээ үнэлгээ тогтмол хийдэг болсон байна.	-	100	Батлагдсан төсвийн хүрээнд
7.4. Тогтвортой үнэ цэнийг бий болгоно.	7.4.1 Дэвшилтэд технологийн шинэчлэлийг нэвтрүүлэх - Аялал жуулчлалын мэдээлэл, үйлчилгээний цахим платформ, аппликейшн хөгжүүлэх	Аялал жуулчлалын мэдээлэл, үйлчилгээний цахим платформ, аппликейшн нэвтрүүлэх VR/AR контент бүхий 2-3 бүтээгдэхүүн гаргасан байна.	-	100	Батлагдсан төсвийн хүрээнд
	7.4.2 Судалгаа, инновац, дижитал шийдлээр тогтвортой хөгжлийг дэмжих	Аяллын урсгал, жуулчны зан төлөвт дүн шинжилгээ хийж, өгөгдөлд суурилсан бодлого боловсруулалт хийдэг болсон байна.	-	100	Батлагдсан төсвийн хүрээнд
7.5. Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдлагыг сайжруулах.	7.5.1 Гүйцэтгэлийн үнэлгээний системийг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлэх.	Гүйцэтгэлийн үнэлгээний KPI системийг байгууллагын түвшинд нэвтрүүлсэн байна.	-	100	-
	7.5.2 Бодлогын баримт бичиг, ISO-9001 2015 чанарын менежментийн тогтолцооны хүрээнд сайжруулалт	ISO-9001 2015 стандартаар батлагдсан хөтөлбөрийн хэрэгжилтийг үе шаттайгаар	-	100	Батлагдсан төсвийн хүрээнд

	хийх	хангах, тогтмол хяналт тавих Чанарын аудит жил бүр хийгдсэн байна.			
7.6. Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголт	7.6.1 Гадаад дотоодын иргэд жуулчдын сэтгэл ханамжийн судалгаа, арга хэмжээний эдийн засгийн үр өгөөжийг тооцож, үр дүнг шийдвэр гаргалтад ашиглах	Сэтгэл ханамжийн судалгааг тогтмол явуулах Судалгааны үр дүнд үндэслэн сайжруулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	-	100	Батлагдсан төсвийн хүрээнд
7.7. Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэл	7.7.1 Стратеги төлөвлөгөөний биелэлтэд 1 жил тутамд хяналт шинжилгээ хийж, стратеги үйл ажиллагааны холболтыг сайжруулах	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Стратегийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийн хэрэгжилтийн биелэлтийг жилийн эцсийн байдлаар НЗДТГ-т хүргүүлсэн байна.	-	100	Батлагдсан төсвийн хүрээнд


ЕС. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА БҮТЦИЙН УЯЛДАА

Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/52 дугаар захирамжаар тус газрын бүтэц, орон тооны хязгаарыг 20, үүнээс дарга-1, Захиргаа, санхүүгийн хэлтэс /7/, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /7/, Мэдээлэл сурталчилгааны хэлтэс /5/ гэсэн зохион байгуулалтын гурван нэгжтэй байхаар баталсан. Мөн Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар “Газрын дүрэм”-ийг шинэчлэн баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Зураг-2. Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг аялал жуулчлалын газрын бүтцийн схем



Зураг-3. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын стратегийн зорилго ба бүтцийн уялдаа



Захиргаа, санхүүгийн хэлтэс стратегийн 7 дахь зорилтыг, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс стратегийн 1, 2, 3, 4 дахь зорилтуудыг, Мэдээлэл сурталчилгааны хэлтэс нь стратегийн 5, 6 дахь зорилтуудыг тус тус удирдан зохион байгуулж ажиллана.

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын стратеги зорилгыг хэрэгжүүлэхэд зохион байгуулалтын нэгж тус бүр өөрсдийн чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна нэгж хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог хангаж ажиллана.